Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 онд байгууллагын дарга 1, удирдлага санхүү аж ахуйн 7, цагдан хорих байрны 23, шийдвэр гүйцэтгэгч 10, нийт 41 орон тоотой ажиллаж байгаад ШШГЕГ-ын 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 06/1318 тоотой 2 орон тоог нэмэгдүүлж, 43 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талуудыг мэдээллээр хангах зорилгоор төлбөр төлөгч, төлбөр авагч нарт цахимаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай танилцах боломжийг олгон 162 төлбөр төлөгч, төлбөр авагчид хэрэглэгчийн нэвтрэх нэр, нууц үгийг олгон ажиллаж байна.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд ШШГЕГ-аас 2 удаа, аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас 1 удаа хяналт хэрэгжүүлж, ШШГЕГ-аас 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 07-3/256 тоотгоор зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус алба нь ШШГЕГ-ын даргын 2020 оны 8 дугаар сарын 20-ний өдрийн А/134 дүгээр тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,636.6 мянган төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	599.6	457.6	-142.0

Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	27,816.7	27,800.0	-16.7
Бараа материал	60,093.3	66,730.5	6,637.2
Үндсэн хөрөнгө	345,820.6	351,978.7	6,158.1
Нийт хөрөнгө	434,330.4	446,967.0	12,636.6
Өр төлбөр	552.8	410.9	-141.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	433,777.6	446,556.1	12,778.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	434,330.4	446,967.0	12,636.6

Дээрх хүснэгтээс харахад: мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 599.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 457.6 мянган төгрөг болж, 142.0 мянган төгрөгөөр буурсан нь цагдан хорих байранд хоригдож буй хоригдол, хоригдогч нарын нэрийн дансны үлдэгдэл 410.9 мянган төгрөг болж буурсантай холбоотой бөгөөд, 46.8 мянган төгрөг нь ахмадын сангийн харилцах дансны үлдэгдэл байна.

Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 60,093.3 мянган төгрөг, ШШГЕГ-ын нэгдсэн хангалтаас 3,121.6 мянган төгрөгийн нормын хувцас, эдийн савангийн хангалт, 172.0 мянган төгрөгийн ном, 114.0 мянган төгрөгийн тусгай хэрэгсэл /батерей/, 1,432.8 мянган төгрөгийн урсгал засварын материал /сапуд төмөр 100 ширхэг/, 2,593.6 мянган төгрөгийн хүнсний хангалт, Өмнөговь аймаг дахь ШШГГ-аас 50.0 мянган төгрөгийн ном, Хорих ял эдлүүлэх албанаас 312.5 мянган төгрөгийн оношлуур зэргийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, улсын төсвийн хөрөнгөөр 109,736.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 111,409.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 675.8 мянган төгрөгийн бараа материалын ангиллыг зөв болгож, данс хооронд шилжүүлэн 2022 оны жилийн эцсийн байдлаар 66,730.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болж 6,637.2 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд түлш шатах тослох материалд 2,757.8 мянган төгрөгийн нөөц бэлтгэсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 345,820.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 351,978.7 мянган төгрөг болж, 6,158.1 мянган төгрөгөөр өссөн нь 6,158.1 мянган төгрөгөөр өсөхөд ТӨБЗГ-ын 2022 оны 6 дугаар сарын 07-ны өдрийн А-1/1175 албан бичгээр Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газраас 42,157.1 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй УАЗ-2206 Фургон авто машин, ШШГЕГ-ын даргын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн А/145 дугаар тушаалаар Хорих ял эдлүүлэх албанаас 4 ширхэг 12,979.6 мянган төгрөгийн иж бүрэн суурин компьютер шилжүүлэн авч улсын төсвийн хөрөнгөөр 12,944.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан зэрэгтэй холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 552.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 410.9 мянган төгрөг болж тус газрын цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдол, хоригдогч нарын нэрийн дансны үлдэгдэлтэй холбоотой 141.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 446,556.1 мянган төгрөг болж 12,636.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 869,534.7 мянган төгрөг, нийт зарлагыг 869,534.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 161,569.8 мянган төгрөгөөр бууруулан ШШГЕГ-ын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/205 дугаар тушаалаар 2022 оны урсгал зардлын төсвийг 707,964.9 мянган төгрөгөөр баталж, улсын төсвөөс 707,750.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 214.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр эх үүсвэрийг баталж ирүүлсэн байна.

Тус байгууллага нь ШШГЕГ-ын Санхүү үйлдвэр, хөрөнгө оруулалтын газарт 2022 оны 11 дүгээр сарын 15-ны 1/1695 тоотой 2,500.0 мянган төгрөгөөр зардал хооронд шилжүүлэн зарцуулах хүсэлт хүргүүлж, өр авлагагүй гарахаар зохицуулалт хийлгэсэн бөгөөд 2022 оны 1 дүгээр сарын 19-ний 1/100 тоотой 4,667.1 мянган төгрөгөөр, 2 дугаар сарын 15-ны 1/228 тоотой 8,407.2 мянган төгрөгөөр, 5 дугаар сарын 13-ны 1/693 болон 7 дугаар сарын 08-ны 1/993 тоотуудаар 27,694.5 мянган төгрөгөөр, 8 дугаар сарын 16-ны 1/1100 тоотой 5,697.2 мянган төгрөгөөр, 9 дүгээр сарын 15-ны 1/1280 тоотой 16,951.9 мянган төгрөгөөр, 10 дугаар сарын 14-ний 1/1490 тоотой 22,719.4 мянган төгрөгөөр тус тус 8 удаа санал хүргүүлсний дагуу тухай бүр тодотголыг хийлгэж 769,648.5 мянган төгрөг болсон бөгөөд ШШГЕГ-аас 12 дугаар сард цалингийн сангаас 5,200.0 мянган төгрөгийн төсвийг буцаан татаж, улсын төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 764,234.5 мянган төгрөгөөр, туслах үйл ажиллагааны орлогыг 214.0 мянган төгрөгөөр баталж, төсвийн нийт зарлагыг 764,448.5 мянган төгрөгөөр тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 707,964.9 мянган төгрөгийг 56,483.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг “шүүхийн шийдвэр гүйцэтгэл” хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 764,234.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 214.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 1,630.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 762,817.6 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 1,630.9 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70705 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	753,403.4	751,772.5	1,630.9	99.8%
2	70705 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80102 Туслах үйл ажиллагааны зардал	214.0	214.0	0.0	100%
3	70705 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80220 Холбооны суваг ашигласны хөлс	1,738.6	1,738.6	0.0	100%
4	70705 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80229 Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	8,672.5	8,672.5	0.0	100%
5	70705 Шүүхийн шийдвэр гүйцэтгэл 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	420.0	420.0	0.0	100%
	Дүн	764,448.5	762,817.6	1,630.9	99.8%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд Төв аймгийн ЗДТГ-аас 500.0 мянган төгрөг, Зуунмод сумын ЗДТГ-аас 10,000.0 мянган төгрөг, Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 1,000.0 мянган төгрөг, Заамар сумын ЗДТГ-аас 30,979.4 мянган төгрөг, ШШГЕГ-аас 2,991.7 мянган төгрөг, нийт 45,471.1 мянган төгрөг төвлөрүүлж, бичиг хэргийн зардалд 2,000.0 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 9,500.0 мянган төгрөг, урсгал засварт 17,741.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 18,230.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт нэг хөтөлбөрийн таван арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70705	2022.01.01-2022.12.31	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл	Хөтөлбөрийн хэрэгжилт 99.8%	764,448.5	762,817.6

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Шүүхийн шийдвэр гүйцэтгэл /70705/ хөтөлбөр 99.8 хувиар хэрэгжсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/116 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 764,448.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 11,466.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,600.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт илтгэх хуудсаар хавсаргаж ирүүлсэн.

ШШГГ-ын 2 алба хаагч 2022 оны 10 дугаар сард тэтгэвэрт гарч, 12 дугаар сард 1 алба хаагч томилогдсонтой холбоотойгоор цалингийн зардлын бодит хэмнэлт 5,200.0 мянган төгрөгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтыг үндэслэн 2022 оны 12 дугаар сарын санхүүжилтийн зарцуулах эрх нээгдсэний дараа ШШГГ-т төвлөрүүлсэн байна.

Цагдан хорих байранд хоригдож буй хоригдол, хоригдогсдын тоо буурсантай холбогдон үүссэн гэрэл цахилгаан зардлын 218.6 мянган төгрөг, цэвэр бохир усны зардлын 1,401.8 мянган төгрөг, нийт 1,630.8 мянган төгрөгийн бодит хэмнэлтийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэсэн заалтын дагуу улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 1 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 15, зарлагын 19 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 41 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага Шүүхийн шийдвэрийн дагуу улсын орлогод төвлөрүүлэх 77,448.6 мянган төгрөгийг 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 3 удаагийн гүйлгээгээр Төв аймгийн Заамар сумын төсвийн орлогын 100141300914 тоот дансанд шилжүүлээд, Төв аймаг дахь ШШГГ-ын 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 1/939 тоот албан бичгээр “нэмэлт санхүүжилтийн 100140012401 тоот дансанд 30,979.4 мянган төгрөгийг шилжүүлэх” хүсэлт Заамар сумын ЗДТГ-т хүргүүлэн 2022 оны 7 дугаар сарын 06-ны өдөр шилжүүлэн орлого авч, Төв аймаг дахь ШШГГ-ын даргын 2022 оны 9 дүгээр сарын 19-ний А/71 тоот тушаалаар захиран зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-д “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, мөн 6.6-д “Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” заалтуудыг зөрчин дэмжлэг авч, тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлээгүй зөрчилтэй асуудал гаргасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 залруулга, 3 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад, 1 залруулгыг хийж, 3 зөвлөмж нь үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 1/769 тоотой Төв аймаг дахь Төрийн аудитын газарт, 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 1/1890 тоотой ШШГЕГ-т хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	1,222.8	1	1,222.8	100%
Зөвлөмж	1	6,831.6	1	6,831.6	100%
Нийт дүн	2	8,054.4	2	8,054.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлснийхээ төлөө шүүхийн шийдвэрийн орлогоос нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар тодорхойлж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 61,537.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 33,737.2 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 27,800.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Шүүхийн шийдвэрийн дагуу улсын орлогод төвлөрүүлэх орлогоос 30,979.4 мянган төгрөгийг тодорхой шийдвэргүйгээр шилжүүлэн дэмжлэг авч, байгууллагын даргын 2022 оны 9 дүгээр сарын 19-ний А/71 тоот тушаалаар захиран зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-д “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, мөн 6.6-д “Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” заалтуудтай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Оршин байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

Түлш шатах тослох материалын дансанд 2.757.8 мянган төгрөгийн шатахууныг нөөцөлсөн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Тасалбар болголт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага хүргүүлэх гэсний дагуу шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тариат харз ХХК-с авах насжилт өндөртэй авлагын оны эхний үлдэгдэл 27,800.0 мянган төгрөгийн шүүхийн шийдвэр гарсан байтал одоог хүртэл барагдуулаагүй он дамнасан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой хянан удирдаж, авлагыг барагдуулах

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул- сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							залруулсан		залруулаагүй			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Дүн	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0	0	0.0

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн										
Шүүхийн шийдвэрийн дагуу улсын орлогод төвлөрүүлэх орлогоос 30,979.4 мянган төгрөгийг тодорхой шийдвэргүйгээр шилжүүлэн дэмжлэг авч,байгууллагын даргын 2022.09.19-ний А/71 тоот тушаалаар зарцуулсан байна.	1	30,979.4			1	30,979.4						
Түлш шатах тослох материалын дансанд 2.757.8 мянган төгрөгийн шатахууныг нөөцлөсөн байна.	1	2,757.8			1	2,757.8						
Насжилт өндөртэй авлагын оны эхний үлдэгдэл 27,800.0 мянган төгрөгийн шүүхийн шийдвэр гарсан байтал одоог хүртэл барагдуулаагүй он дамнасан зөрчил байна.	1	27,800.0					1	27,800.0				
Дүн	3	61,537.3	0	0.0	2	33,737.3	1	27,800.0	0	0.0	0	0.0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0